

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРААС 2026 ОНЫ
03 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 26

Багануур дүүрэг

Сэдэв: Нийгмийн даатгалын хууль эрх зүй, практик сургалт

Нэг. Сургалтын зорилго

Ажил олгогчдод Нийгмийн даатгалын багц хуулийг танилцуулах, цахим системийн (portal.ndaatgal.mn) ашиглалтыг сайжруулах, шимтгэлийн тайлан бэлтгэхэд гардаг нийтлэг алдааг засварлах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хоёр. Сургалтын зохион байгуулалт ба хамрах хүрээ

Тайлант хугацаанд хууль эрх зүй, практик сургалтыг тус бүр 1 удаа зохион байгууллаа.

1. Танхимын сургалт (2026.03.11)

Нийт 19 ажил олгогч байгууллагын 30 төлөөлөл (удирдлага, нягтлан бодогч, хүний нөөц) хамрагдсан. Сургалтаар хуулийн хэрэгжилт болон тэтгэмжийн асуудлаар онолын мэдээлэл өгч, "Quiz time" асуулт хариултын тэмцээнээр мэдлэгийг бататгасан.



Сургалтад дараах сэдвүүдээр тус газрын дарга, хэлтсийн дарга, байцаагч мэргэжилтнүүд мэдээлэл өгч, зөвлөв.

№	Сэдвийн нэр	Сургагч ажилтны албан тушаал, нэр
1	"Нийгмийн даатгалын тухай ойлголт, ач холбогдол" (Хуулийн шинэчлэлийн хүрээнд)	Газрын дарга Р.Өнөржаргал
2	"Ажил олгогчдод зориулсан цахим системийн ашиглалт, анхаарах асуудал"	Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Г.Батболд
3	"Шимтгэл төлөлттэй холбоотой гарч буй нийтлэг алдаа, анхаарах асуудал"	Хамралт, орлого, шимтгэлийн байцаагч Ц.Солонго
4	"Эмнэлгийн хуудас, хөдөлмөрийн чадвар алдалтын тухай"	Магадлагч эмч Б.Балжинням

Хамрагдсан байгууллагууд (19)

- 131 дүгээр цэцэрлэг
- 132 дугаар цэцэрлэг
- 138 дугаар цэцэрлэг
- 193 дугаар цэцэрлэг
- 235 дугаар цэцэрлэг
- 288 дугаар цэцэрлэг
- Авто зам засвар арчлалтын нэгтгэл (Багануур салбар)
- Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар
- Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл
- Багануур залуус төв ААТҮГ
- Багануур телекамерын төв ОНӨААТГ
- Да экюпмент ХХК

- Монголын цахилгаан холбоо ТӨКХ (Багануур салбар)
- Насан туршийн суралцахуйн төв
- НИК ХХК (Багануур салбар)
- Номин бизнес клуб ХХК
- Соёлын ордон
- Хас банк (Багануур салбар)
- Хилийн цэргийн 252 дугаар анги



2. Практик сургалт (2026.03.25)

Сургалтад нийт 10 ажил олгогчийн төлөөлөл 11 хүн (удирдлага, нягтлан бодогч, хүний нөөц) оролцсон. Энэхүү сургалт нь шимтгэлийн тайланг цахим системд алдаагүй, шуурхай илгээх практик дадлагад суурилсан.

Сургалтыг дараах сэдвүүдээр СБХОХэлтсийн дарга, байцаагч нар мэдээлэл өгч, дадлага ажлыг зохион байгуулав.

№	Сэдвийн нэр	Сургагч ажилтны албан тушаал, нэр
1	Шимтгэлийн тайлан бэлтгэх	Хамралт, орлого, шимтгэлийн байцаагч Ц.Солонго

2	Цахим системд тайлан илгээх	Хамралт, орлого, шимтгэлийн байцаагч Ц.Солонго
3	Шимтгэл төлөлттэй холбоотой гарч буй түгээмэл алдаа, хэрхэн засварлах	Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч Г.Батболд

Хамрагдсан байгууллагууд (10)

- Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар
- Багануур сувилал ХХК
- Голомт банк (Багануур салбар)
- Дорно мандал МАМИ ХХК
- Жаргалантай сайхан ХХК
- Мөнхдөл констракшн ХХК
- НИК ХХК (Багануур салбар)
- Өгөөмөр цагаан шувуут ХХК
- Цахирт-Ану ХХК
- Энх-Өрх өрхийн эмнэлэг




Гурав. Дүгнэлт

Сургалтын үр дүнд ажил олгогч байгууллагуудын төлөөллүүд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл болон цахим системийн ашиглалтын талаар нэгдсэн ойлголттой боллоо.

Оролцогчид цахим үйлчилгээ авах явцад тулгардаг техникийн болон арга зүйн асуудлуудаа газар дээр нь асууж харилцан ярилцаж, мэргэжлийн зөвлөгөө мэдээллийг авсан үр дүнтэй уулзалт болов.


Цаашид ажил олгогчдын нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, тайлан илгээх явц дахь алдааг бууруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор уг сургалтыг сар бүр тогтмол, идэвхтэй зохион байгуулах талаар сургалтад хамрагдаагүй ажил олгогч байгууллагуудад мэдээллэн ажиллаж байна.

ХЯНАСАН:
САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАМРАЛТ,
ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ



Г.БАТБОЛД

БОЛОВСРУУЛСАН:
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТ
СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛТАН



Г.СҮХБОЛД